

ГОВЬСҮМБЭР АЙМАГ
ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН
ХӨГЖЛИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2021 оны 02 сарын 17 өдөр

Дугаар 113

Сүмбэр сум

“Ирээдүйн хөтөч” уран
илтгэлийн цахим уралдаанд
хөрөнгө зарцуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Захирааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 43.2, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.3, Залуучуудын хөгжлийн үндэсний хөтөлбөрийн 5 дугаар зүйлийн 5.4.1, аймгийн Засаг даргаар батлуулсан 2021 оны байгууллагын Гүйцэтгэлийн төлөвлөгөөний 16 дугаар зорилтыг тус тус үндэслэл болгон ТУШААХ нь:

1.“Ирээдүйн хөтөч” уран илтгэлийн цахим уралдааны удирдамжийг нэгдүгээр хавсралтаар, төсвийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.“Ирээдүйн хөтөч” уран илтгэлийн цахим уралдааныг зохион байгуулж, үр дүнг тайлагнахыг Залуучуудын асуудал хариуцсан мэргэжилтэн (Б.Урангоо)-д даалгасугай.


3.Тус үйл ажиллагаанд зарцуулагдах 450 000 (дөрвөн зуун тавин мянга) төгрөгийг бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлаас гаргахыг нягтлан бодогч (Д.Оюунцэцэгт)-д даалгасугай.

ДАРГА



Ц.ОЮУНБИЛЭГ

914
ГБХЗХГазрын даргын 2021 оны
02 сарын 17-ний өдрийн
дугаар тушаалын 1-р хавсралт



“ИРЭЭДҮЙН ХӨТӨЧ-2021” УРАН ИЛТГЭЛИЙН ЦАХИМ УРАЛДААНЫ УДИРДАМЖ

Говьсүмбэр аймаг

Нэг. Үндэслэл, хэрэгцээ

Дэлхий нийтээр тархаад буй цар тахал /Ковид-19/-ын улмаас Монгол улсын Засгийн газраас өндөржүүлсэн бэлэн байдал зарлан төрийн болон төрийн бус байгууллагын үйл ажиллагаа цахим хэлбэрт шилжин ажиллах болсонтой холбогдуулан залуучуудыг соён гэгээрүүлэх хөгжлийн сургалт, нөлөөллийн үйл ажиллагааг цахим хэлбэрээр санаачлагатай, шинэлэг, бүтээлч байдлаар зохион байгуулж залуусыг идэвхжүүлэх хэрэгцээ шаардлага бий болж байна.

Хоёр. Зорилго

Өсвөр үе залуучуудын нийгмийн оролцоог нэмэгдүүлэх, өөрсдийн эрх, үүрэг, хариуцлагын талаарх мэдлэгийг дээшлүүлэх, залуучуудын дунд тулгамдаж буй асуудлыг тодорхойлж, шийдлийг эрэлхийлэх, цаг үеийн нөхцөл байдал /хөл хорио/-тай холбоотой залуусын чөлөөт цагийг үр дүнтэй бүтээлч өнгөрөөх, хөгжих боломжийг нэмэгдүүлэхэд гол зорилго оршино.

Гурав. Зохион байгуулагч

Говьсүмбэр аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Залуучуудын хөгжлийн төв

Дөрөв. Хамрах хүрээ, насны ангилал

1. Говьсүмбэр аймгийн харьяат иргэн байна.
2. Ерөнхий боловсролын сургуулийн сурагчид 9-12 дугаар анги
3. 18-34 насны нийт залуучууд

Тав. Илтгэлийн сэдэв

- ✓ Хувь хүний хөгжил ба боломж
- ✓ Өсвөр үе залуучуудын харилцаа хандлага
- ✓ Цар тахлыг эерэгээр даван туулах нь
- ✓ Цахим орчинд эерэг хандлагыг бий болгох арга зам
- ✓ Надад мөрөөдөл бий
- ✓ Шинэ цагийн залуу хүн ба түүнийг бий болгох нь зэрэг сэдвүүдээс сонгож авна.

Зургаа. Зохион байгуулалт

- ✓ Илтгэлийн уралдааныг цахимаар зохион байгуулна. /Оролцогчдын илтгэлийг цахимд байршуулахгүй/
- ✓ Оролцогчид сонгон авсан сэдвийн хүрээнд 3-5 минутын видео бичлэг хийж уран тод илтгэнэ.
- ✓ Ирүүлсэн бичлэгийг зохион байгуулагчид болон шүүгчийн зүгээс насны ангилал тус бүрээр шалгаруулалт хийж шагналт байранд тодорхойлно.
- ✓ Шагналт байранд шалгарсан илтгэлийг ГБХЗХГ-ын албан ёсны фэйсбүүк цахим хуудас болон Говьсүмбэр Залуучуудын хөгжлийн төвийн фэйсбүүк цахим хуудсаар тус тус дамжуулан нийтэд хүргэнэ.

Долоо. Илтгэл хүлээн авах хугацаа, хаяг

2021 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн 17:00 цаг хүртэл Говьсүмбэр Залуучуудын хөгжлийн төв фэйсбүүк цахим хаягаар хүлээн авна.

Найм. Илтгэлд тавигдах ерөнхий шаардлага

- ✓ Өгсөн сэдвийн хүрээнд онол арга зүйн болон практик талаас нь судлан тодорхойлж, төлөв байдал, хэтийн хандлагын талаар шинэ шийдэл, санааг дэвшүүлсэн байх
- ✓ Мэдээлэл боловсруулах аргачлал болон бодит кейс, судалгаанд тулгуурласан байх / Хүний нэр төрд халдахгүй байх/
- ✓ Зохиогчийн эрхийн зөрчилгүй судалгааны өргөн мэдээлэлд үндэслэсэн байх
- ✓ Видео бичлэг дүрс, дуу бичлэгийн шаардлага хангасан байх

Ес. Шалгаруулалт


1. Нэг үе шаттайгаар зохион байгуулна.
2. Шүүгчдийн бүрэлдэхүүн оролцогчдын илтгэх ур чадвар, сэдэв агуулга, цаг баримтлах чадвар, судалгаа, гарц дүгнэлт зэргийг харгалзан ангилал тус бүрд эхний 3 байр эзлүүлнэ.

Арав. Холбоо барих

Цахим хаяг: Говьсүмбэр Залуучуудын хөгжлийн төв
 Утас: 90050051,70543661
 И-мэйл хаяг: gsa.fcy@gmail.com

УДИРДАМЖ БОЛОВСРУУЛСАН:
 ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖИЛ, ОРОЛЦОО
 ХАРИУЦСАН АЖИЛТАН Б.УРАНГОО

ГБХЗХГазрын даргын 2021 оны
...сарын 17-ний өдрийн...
дугаар тушаалын 2-р хавсралт



“ИРЭЭДҮЙН ХӨТӨЧ-2021” УРАН ИЛТГЭЛИЙН ЦАХИМ УРАЛДААНЫ
ТӨСӨВ

№	Бараа материалын нэр	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	Өргөмжлөлийн жааз	6	5000	30000
2	Ном	6	30000	180000
3	Мөнгөн шагнал	2	50000	100000
	1-р байр	2	40000	80000
	2-р байр	2	30000	60000
Нийт үнэ				450000